



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 02 сарын 28 өдөр

Дугаар А/119

Номгон

Г.Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяраар
ахлуулсан шуурхай бүлэг, УИХ-ын дарга
Г.Занданшатар нарын Баянхонгор аймагт
ажилласантай холбогдуулан хөрөнгө
зарцуулах тухай

Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.9, Сангийн сайдын 2021 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн 61 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журмын 2.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Улсын онцгой комиссын өвс тэжээлийн буцалтгүй тусламжийг сумдад тараах, өвөлжилт, хаваржилтын байдалтай танилцах зорилгоор Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяраар ахлуулсан шуурхай бүлэг болон Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар нар Баянхонгор аймагт ажилласантай холбогдуулан гарсан зардал болох 6,484,100 (Зургаан сая дөрвөн зуун наян дөрвөн мянга нэг зуун төгрөг)-ийг Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Д. Энхжаргал)-т зөвшөөрсүгэй.

2. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Б.Батсуурь)-д даалгасугай.

ДАРГА  Д.МӨНХСАЙХАН

624010211